



БАЯНХОНГОР АЙМАГ
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/120

Баянсайр

Дархлаажуулалтын аяныг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. дэх, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулалтын тухай” А/512 дугаар тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2022 оны 10 сарын 21-ний өдрөөс 30-ны хүртэлх хугацаанд “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулсугай.

2. Бүгд Найрамдах Солонгос Улсын Грийн кросс үйлдвэрийн улирлын томуугийн вакцинаар эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 1-5 нас хүртэлх хүүхэд, эрсдэл бүлгийн хүн ам, эрүүл мэндийн ажилтныг вакцинжуулах аяныг чанартай, үр дүнтэй зохион байгуулахыг Эрүүл мэндийн төв (Д.Болормаа)-д үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын 10 хоногоор заавал хийх дархлаажуулалтаас хоцорсон 0-15 насны хүүхдийг нөхөн дархлаажуулах, дархлаажуулалтын ач холбогдлыг ард иргэдэд олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлан таниулахыг Эрүүл мэндийн төв (Д.Болормаа)-д анхааруулсугай.

4. Дархлаажуулалтын 10 хоногийн “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулсан ажлын тайланг 2022 оны 11 сарын 01-ний дотор аймгийн Эрүүл мэндийн газар, сумын Засаг даргын тамгын газарт тайлагнахыг Эрүүл мэндийн төв (Д.Болормаа)-д даалгасугай.

ДАРГА

С.ЭНХТӨР



642201025

zahiramj_tushaal\Захирамж-2020-01.docx